

Product Data Sheet

Edition 1, 2004

Sika® Latex 25A

Sika® Latex 25A

Усны хамгаалалттай, барьцалдан наалдах чадварыг сайжруулагч зуурмагын нэмэлт

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika® Latex 25A нь сайжруулсан стирол бутадиен эмульс юм. Найрлаган дахь полимерын нөлөөллөөр Sika® Latex 25A бүхий зуурмаг нь маш өндөр наалдамхай чанартай, шахалтын бат бэх болон гулзайлт, суналтын бат бэхтэй шавардлага болно. Sika® Latex 25A-тай шавардлага нь ус болон химийн бодисын дайралтад өндөр тэсвэртэй хоргүй, зэвэрдэггүй, мөн хөлдөлт, гэсгээлтэнд онцгой тэсвэртэй шавардлага болно. Sika® Latex 25A бүтээгдэхүүнийг барилгын салбарт нийлүүлээд 20 гаран жилийн нүүрийг үзэж байна.

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

Sika® Latex 25A бүхий зуурмаг хэрэглэсний давуу талууд:

- Өндөр бат бэхтэй шалны бетон
- Бетоныг нөхөх, дүүргэх засварын зуурмаг
- Бетоныг нөхөх, дүүргэх зориулалттай нимгэн зуурмаг
- Гулзайлт болон хагарал ан цавд тэсвэртэй тоосжилтын үүсдэггүй шалны бетон
- Sika-1 системийн суурь барьцалдуулах түрхлэг зориулалтаар, мөн цэвэр усны танк болон бохирыг танк хоолойн гадна түрхлэг зориулалтаар хэрэглэж элэгдэлд тэсвэртэй хамгаалалт үүснэ.

Техникийн мэдээллүүд

Төрөл Шингэн Стирол Бутадиен

Өнгө Цагаан

Нягт (+20°C орчинд) ~ 1,00 кг/л

Хуурай хэсгийн агууламж (%) 25 ±1

pH 7,5 ± 0,5

Хадгалах газар Хөлдөх аюулгүй хуурай орчин

Sika®

Хадгалах хугацаа

Үйлдвэрээс савлагдсан савлагаанд тагийг нь нээгээгүй тохиолдолд 12 сар хадгалах боломжтой.

Сав баглаа боодол

20 кг-ийн хуванцар савтай

Зөвшөөрлүүд

- Ундны устай хүрэлцэх WFBС-д бүртгэлтэй (Бүртгэлийн дугаар 8905507). Ундны устай хүрэлцэх цементэн зуурмагт хэрэглэхэд тохиромжтой.
- Хонг Конгийн Барилгын Тодорхойлолт ТМ 1 - ТМ 8, Зэрэг- 40

Хэрэглээ

Гадаргууг бэлдэх

Гадаргуу бат бэх байж, элдэв бохирдол, тоосноос сайтар цэвэрлэсэн байх шаардлагатай. Сул, хөдөлгөөнтэй, бутрамтгай хэсгүүдийг тогшилтод алх болон зүлгүүрийн машинаар хуулж авах шаардлагатай. Хэрэв гадаргуу нь нүх сүв ихтэй байвал гадаргууг жигд чийглэх хэрэгтэй. Гадаргуун дээр илүүдэл тогтсон ус үлдээж болохгүй.

Барьцалдуулах зуурмаг

Барьцалдуулах зуурмагыг бетон, тоосго, блокон хавтан, шавардлага болон Sika-1 ус тусгаарлагч болон шалны шавардлагаанд хэрэглэнэ.

- Дараах найрлагын дагуу жигд зуурмаг болтол холих хэрэгтэй:
Ус : Sika Latex 25A харьцаа 1:1
Цемент : Угаасан нарийн элс харьцаа 1:1
(Sika Latex 25A-ийн зарцуулалт 4-5м²/литр)
- Бэлдсэн зуурмагыг урьдчилан чийглэсэн талбай дээр нарийн шүдтэй сойзоор хангалттай хэмжээгээр түрхэж өгөх.
- Барьцалдуулах зуурмагыг гадаргуу дээр хатахаас өмнө шавардлагааны зуурмагаа түрхэнэ.

Ерөнхий зөвлөмжүүд

- Sika Latex бүхий барьцалдуулах зуурмагыг цемент болон элсгүйгээр найруулж болохгүй. Ус, Sika Latex 25A-ийг холих хамгийн өндөр харьцаа 1 : 1 (Ус: Sika Latex) байна.
- Sika Latex бүхий зуурмагыг бетоны жирийн холигчоор зуурч болохгүй, зориулалтын эргэлтэд хошуу бүхий цахилгаан дриллээр хольно.
- Ус цементийн харьцаа бага байх тусам ажиллах чадвартай, нягтрал сайтай шавардлага болно. Тохиромжит ус цементийн харьцаа 0.4-өөс бага байна.
- Sika Latex 25A бүхий зуурмагыг хэт удаан хольж болохгүй.
- Модон болон төмөр нивигээр шавардлагааны төгсгөл үе давхрагыг шавардаж жигд өнгөлнө. Sika Latex 25A бүхий шавардлагааг бэхжилтийн үед хуурайшихаас сэргийлж арчилгаа хийх хэрэгтэй. Үүний тулд гадаргууг чийглэж, полиэпилэн гялгар хучлагаар хучиж, арчилгааны бүтээгдэхүүнүүдийг түрхэх хэрэгтэй. Угаасан, хурц үзүүрт хайргыг заавал ашиглана.
- Хамгийн зузаан шавардлагын хэмжээ 40 мм байна (Дараагийн хуудастай танилц)

■ Бэхжиж хатуурсан үе давхрагууд сайтар барьцалдсан, чийглэгдсэн болон даралттайгаар шахаж шавардсан эсэхийг тогтмол шалгаж байх шаардлагатай.

■ Шалны бетон, шавардлагын арчилгааг зөв хийх хэрэгтэй Хэрэв орчны температур 0°C хэмээс доош буувал (гүйцэтгэлийн хамгийн бага температур) бэхжээгүй шавардлагыг хөлдөхөөс хамгаалах шаардлагатай.

Түүхий эд материалууд

Нарийн зэрэглэж, сайн угаасан элс хайргыг хэрэглэх, цемент нь шинэ OPC цемент байх ёстой. Гадаргуун түвшин, шавардлагын зузаанаас хамааран хайрга дүүргэгчийн хэмжээ тодорхойлогдоно.

Дүүргэгчийн их, бага хэмжээ, Шавардлагааны зузаан

0 - 0,5 мм	2 мм-ийн зузаантай шавардлагаанд
0 – 1,0 мм	2 – 5 мм-ийн зузаантай шавардлагаанд
0 – 3,0 мм	5-15 мм-ийн зузаантай шавардлагаанд
0 – 7,0 мм	15мм-ээс дээш зузаантай шавардлагаанд

Орц найрлага дахь усны агууламжийг аль болох бага хэмжээнд хийх шаардлагатай.

НАЙРЛАГЫН ТАЙЛБАР	НАЙРЛАГА 1	НАЙРЛАГА 2	НАЙРЛАГА 3	НАЙРЛАГА 4	НАЙРЛАГА 5	НАЙРЛАГА 6	НАЙРЛАГА 7
Энгийн ба санал болгож буй хэрэглээ	Стандарт шавардлагууд: Ус тусгаарлагч / шалны нөхөөс / Шалны шавардлага / Чулуун тоосгон өрлөгийн шавардлага. Гадаргуунд чийг болон барьцалдуулах зуурмагтай шаардлагатай	Өндөр үзүүлэлттэй шавардлага: Химийн болон физик дайралтад тэсвэртэй шавардлагууд / ус тусгаарлагч шавардлагууд. Эдэлгээнд тэсвэртэй өндөр гүйцэтгэлтэй шавардлагууд. Гадаргуунд чийг болон барьцалдуулах зуурмагтай шаардлагатай	25 мм-ийн зузаантай өндөр ачаалал бүхий шалны шавардлага. Үйлдвэрийн шалны нөхөөс шавардлага. Гадаргуунд чийг болон барьцалдуулах зуурмагтай шаардлагатай	Найрлага-2-ийн үйлчлэлийг хурдан бэхжүүлэх хувилбар. Хүйтний улирлын засвар болон хурдан бэхжүүлэх засваруудад зориулагдсан. Гадаргуунд чийг болон барьцалдуулах зуурмагтай шаардлагатай	Тоосго, Плита, Хучилтын чулуун хавтан, замын хашлага зэрэгт зориулагдсан цавуулаг шавар	75 мм-ээс гүн нүх бүхий бетоны засвар болон усанд тэсвэртэй цутгалтын “Микро-бетон” шавардлага	Агшдаггүй, усанд тэсвэртэй шавардлага. Жишээ нь: ан цавыг битүүлэх, мө хөндийрсөн шавардлагын бэхжүүлэх зорилгоор хийгдэх шавардлага
ОРЦЫН НАЙРЛАГА (Хайргыг хуурай гэж тооцсон болно)							
OPS Цемент	50 кг	50 кг	50 кг	50 кг	50 кг	50 кг	50 кг
Элс	125 кг	125 кг	75 кг	125 кг	125 кг	125 кг	75 кг
Хайрга	-	-	(3-5мм) 75 кг	-	-	-	(5-10мм) 120 кг
Sika Latex 25A	7 литр	9 литр	6 литр	7 литр	7-9 литр	9 литр	7 литр
Ус	12 литр хүртэл	9 литр хүртэл	12 литр хүртэл	12 литр хүртэл	9 литр хүртэл	9 литр хүртэл	13½ литр хүртэл
Нэмэлт	-	-	-	-	Sika-3 2 литр	-	(Sikament) 0.4 л
Шахалтын бат бэх	28 хоног 50-60 кг/см2	28 хоног 50-60 кг/см2	28 хоног 55-65 кг/см2	28 хоног 50-60 кг/см2	28 хоног 45-55 кг/см2	28 хоног 45-50 кг/см2	28 хоног 45-50 кг/см2

Эзлэхүүн	0,09 м³	0,09 м³	0,10 м³	0,10 м³	0,09 м³	0,11 м³	0,04 м³
Санамж	Гадаргуун зузаан 12 мм-ээс хэтэрсэн тохиолдолд 25 кг элс нэмж өгөх хэрэгтэй	12 мм-ээс илүү шавардлага хийх талбайд 25 кг элс нэмж өгөх хэрэгтэй	Хагас хуурай шавардлага. 25 мм-ээс илүү зузаан шавардлага хийх тохиолдолд 4 литр Sika Latex орно.	Энэ найрлаганд Sika-3 буюу Кальцийн Хлорид агуулсан тул хаигаалалтгүй төмөр хийц эдлэл болон төмөр арматурчлалтай бетоны засварт хэрэглэж болохгүй.	Нимгэн чигжээс бүхий хэсэгт 4-р төрлийн элсийг хэрэглэх. Усны орцыг хамгийн багад хийх.	Хэв хашмал зай завсаргүй сайтар чигжсэн эсэхийг шалга. Доргиур өгөх шаардлагатай.	Аль болох богино хугацаанд хийх, шаардалтаг тохиолдолд насосоор шахна. Боломжтой газарт чийглэж өгөх хэрэгтэй.

Анхаарах зүйл

Дээр дурдсан хэрэглээний хувилбаруудын хувьд элсний чийгийг хуурай буюу 0 гэж тооцоолсон болно. Тиймээс бодит байдал дээр хэрэглэгдэх элс хайрганы чийгшлийн хэмжээг тооцож, устай харьцах Sika Latex 25A-ийн орцын хэмжээг зөв тодорхойлох хэрэгтэй.

Хууль эрх зүйн мэдээлэл Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.